



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2023 оны 10 сарын 19 өдөр

Дугаар 50У

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгийг балансаас балансад
шилжүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсгийн 1 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Гаалийн ерөнхий газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 126,000,000.00 (нэг зуун хорин зургаан сая) төгрөгийн балансын үнэ, 115,500,000.00 (нэг зуун арван таван сая таван зуун мянган) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу Хил хамгаалах ерөнхий газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Гаалийн ерөнхий газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Р.Отгонжаргал, Хил хамгаалах ерөнхий газрын дарга, бригадын генерал Х.Лхагвасүрэн нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчдийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2023 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 10 дугаар сарын 10 өдрийн
50% дугаар тогтоолын хавсралт

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, ХИЛ ХАМГААЛАХ ЕРӨНХИЙ ГАЗАРТ
БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, марк	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Хэм жих нэгж	Ашиглалтад орсон огноо	Тоо хэм жээ	Балансын нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	
1	Суудлын автомашин, Ниссан патрол Y62, 05-31 УБҮ (арал-jn1tanu62z0030042)	126,000,000.00	ш	2018.04.29	1	126,000,000.00	115,500,000.00	10,500,000.00	
	Нийт дүн						126,000,000.00	115,500,000.00	10,500,000.00